

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 04 дүгээр сарын 21

Улаанбаатар хот

Д/Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг, даалгавар-НЭГ:</b> Захиалагчийн хяналт тавьж байгаа, болон эрх шилжүүлсэн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, зураг төсөв, ажлын даалгаваргүй, байршил тодорхойгүй байгаа ажлуудаа яаралтай шийдвэрлэж, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг бүрэн хангах.				
1.	<p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/140 дугаар захирамжаар дүүрэгт эрх шилжиж ирсэн нийт 3 ажил байна. Үүнд:</p> <p>1. Чандмань овооны тохижилт /14 дүгээр хороо/ - ЧД-ийн Худалдан авах ажиллагааны алба дээр 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тендер зарлагдсан, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр нээнэ.</p> <p>2. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил – 1 /ЧД/ 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр тендер зарлагдсан, 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр нээнэ.</p> <p>Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах /ЧД/ – дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/772 дугаар албан бичгээр зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг хүргүүлсэн болно.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/140 дүгээр захирамжаар эрх шилжиж ирсэн нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 19, нийт 22 төсөл арга хэмжээ 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсанаас 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 22 төсөл, арга хэмжээ 100 хувь зарлагдсан бөгөөд тендерийг хүлээн авах, үнэлгээ хийх, шалгарсан оролцогчид мэдэгдэл дүгнэлтийг хүргүүлэх, амжилтгүй болсон тендерүүдийг дахин зарлах зэрэг ажиллагаанууд хийгдэж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
<b>Үүрэг, даалгавар ХОЁР:</b> Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад төсвийн тодотгол хийх бэлтгэл ажлыг сайтар хангаж, нийт байгууллагууд төсвийн сахилга батыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжүүлж ажиллах.				
2.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 4/641 тоот албан бичгээр Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 68 байгууллагад төсвийн тодотгол хийх бэлтгэл ажлыг хангах хүрээнд хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа ирүүлэх мөн Засгын Газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг баримтлан ажиллах талаар чиглэл хүргүүлэн ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30